



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/58/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе аудит” ХХК-ийн
Захирал П.Ариунаа
Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	14
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	14
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	14
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	15
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	17
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
5.1 Шилэн дансны мэдээлэл	19
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
8. Аудитын илрүүлэлт	20
8.1 Албан шаардлага.....	21
8.2 Зөвлөмж	23
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	26
10. Хавсралт: Албан шаардлага	31

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022 03.15 № 07/628
танай _____ -ны № _____ -т

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Х.БАДАМСҮРЭН ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх” зааврын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 230,946.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, материаллаг боловч өргөн тархаагүй, СТОУС16 Үндсэн хөрөнгө, Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт, СТОУС9 Санхүүгийн хэрэглүүр, Авлага, НББОУС37 Болзошгүй хөрөнгө, өр төлбөр ба нөөц, НББОУС2 Бараа материал, Дайвар бүтээгдэхүүн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон зүйлс

Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 42,358.7 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна. Банкны төлбөрийн чадвараас шалтгаалан тухайн дансанд байршиж буй мөнгөн хөрөнгө 2020 оны 4 сараас хойш гүйлгээ хийх боломжгүй болж хязгаарлалтад орсон байна. Медипас ХХК-тай 2016 онд гэрээ байгуулж, 64,871.5 сая төгрөгийн эмнэлгийн байр,

тоног төхөөрөмж, ажилчдын орон сууц зэрэг хөрөнгийг хүлээлгэн өгч 18 жилийн хугацаанд жил бүр тогтмол дүнгээр эргэн төлөх нөхцөлтэй авлага үүсгэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 2 сарын 28-ны өдрийн 78 дугаар тогтоолын дагуу Медипас ХХК-ийн хөрөнгийг буцаан хүлээн авах үйл ажиллагаа эхэлсэн. Хүлээн авах хөрөнгийн үнэ цэнэ тодорхойгүй байгаагаас Медипас ХХК-аас авах авлагын үнэ цэнэ буурсан эсэх нь тодорхойгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын 1. "Айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс харилцан төлөх, тус тогтоолын 7. "Энэ тогтоолын 1-д заасны дагуу төлбөр хураамжийг төрөөс хариуцахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн цэвэр ашгаас тооцож, санхүүжүүлэх арга хэмжээ авах"-аар тогтоосон. Дээрх тогтоолын хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 1,036,846.9 сая төгрөгийн өглөг тооцоолсноос 883,487.7 сая төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлээд байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны нийт орлогыг 2,442,541.3 сая төгрөг, нийт зардлыг 1,880,061.6 сая төгрөг, ашгийг 562,479.7 сая төгрөг ба хөрөнгө оруулалтын зардалд 892,663.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 3,130,390.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,893,083.1 сая төгрөгийн зардал гарган, 901,547.5 сая төгрөгийн ашигтай, 436,866.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд нийт 854 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 48.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	106,035,763,809.53	64,648,059,812.02
1.1.2	Дансны авлага	25,952,682,220.07	15,342,441,874.47
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	102,389,885,037.04	488,175,026.21
1.1.4	Бусад авлага	7,146,099,921.10	48,818,636,942.54
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	305,345,018,824.83	414,956,675,473.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	73,066,772,957.93	92,179,037,617.10
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,568,900,000.00	336,000,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	621,505,122,770.50	636,769,026,746.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,281,858,547,500.43	2,464,827,989,682.16
1.2.2	Биет бус хөрөнгө	2,482,332,314,812.71	2,482,700,523,939.45
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	7,383,888,061.64	8,563,097,755.26
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	56,734,435,450.35	71,541,418,478.55
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	48,507,228,776.15	72,847,245,676.23
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	778,910,310.09	708,655,830.09
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	34,526,665,241.25	35,167,000,167.43
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,912,121,990,152.62	5,136,355,931,529.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,533,627,112,923.12	5,773,124,958,275.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	77,554,537,755.34	113,643,706,195.44
2.1.1.2	Цалингийн өглөг	28,475,451,764.15	25,359,954,903.04
2.1.1.3	Татварын өр	11,220,131,815.61	119,426,297,311.39
2.1.1.4	НДШ–ийн өглөг	1,195,738,350.44	464,823,781.65
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	115,605,984,621.88
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	53,385,742.62
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	51,567,935,517.90	152,945,519,787.86
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	33,746,399,363.70	41,619,209,549.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	23,060,687,560.86	183,414,431,612.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	226,820,882,128.00	752,533,313,504.88

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	188,843,157,677.16	237,927,969,442.41
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	188,843,157,677.16	237,927,969,442.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	415,664,039,805.16	990,461,282,947.29
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	2,658,321,900.00	2,658,321,900.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	828,350,189,857.57	800,832,767,774.59
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,473,982,832,000.00	2,473,982,832,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,812,971,729,360.39	1,505,189,753,653.36
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,117,963,073,117.96	4,782,663,675,327.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,533,627,112,923.12	5,773,124,958,275.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,173,290,907,146.74	3,093,882,568,149.00
2	Борлуулалтын өртөг	966,852,517,764.49	981,342,950,456.50
3	Нийт ашиг(алдагдал)	1,206,438,389,382.25	2,112,539,617,692.50
4	Түрээсийн орлого	209,719,636.61	96,701,661.00
5	Хүүгийн орлого	11,379,384,722.75	2,087,986,835.43
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	13,603,346,771.03	22,267,957,376.38
9	Борлуулалт, маркетингийн зардал	397,466,255,127.80	640,720,195,702.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	123,787,160,483.11	119,087,602,109.60
11	Санхүүгийн зардал	-	53,385,743.00
12	Бусад зардал	97,163,386,640.82	150,139,756,674.34
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,285,602,500.06	5,890,191,045.29
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(314,145,379.17)	(1,739,245,726.98)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний олз (гарз)	(188,766,423,049.00)	-
17	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
18	Бусад ашиг (алдагдал)	3,035,395,119.00	6,165,459,694.00
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	429,454,467,451.80	1,237,307,728,348.68
20	Орлогын татварын зардал	166,353,954,439.19	335,760,249,639.23
21	Татварын дараах ашиг (алдагдал)	263,100,513,012.61	901,547,478,709.45
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	263,100,513,012.61	901,547,478,709.45
24	Бусад дэлгэрэнгүй орлого	3,130,622,958,982.00	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	656,640,126,982.00	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	2,473,982,832,000.00	-
25	Орлогын нийт дүн	3,393,723,471,994.61	901,547,478,709.45
26	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,658,321,900.00	180,882,935,839.37	3,568,648,238.78	1,691,729,691,077.00	1,878,839,597,055.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(6,054,910,531.80)	(3,568,648,238.78)	10,063,562,838.78	440,004,068.20
Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	174,828,025,307.57	-	1,701,793,253,915.78	1,879,279,601,123.35
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	263,100,513,012.61	263,100,513,012.61
Бусад дэлгэрэнгүй орлого	-	656,640,126,982.00	2,473,982,832,000.00	-	3,130,622,958,982.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(155,040,000,000.00)	(155,040,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(3,117,962,432.00)	-	3,117,962,432.00	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,658,321,900.00	828,350,189,857.57	2,473,982,832,000.00	1,812,971,729,360.39	5,117,963,073,117.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	828,350,189,857.57	2,473,982,832,000.00	1,812,971,729,360.39	5,117,963,073,117.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	901,547,478,709.45	901,547,478,709.45
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(1,036,846,876,499.46)	(1,036,846,876,499.46)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(200,000,000,000.00)	(200,000,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(27,517,422,082.98)	-	27,517,422,082.98	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,658,321,900.00	800,832,767,774.59	2,473,982,832,000.00	1,505,189,753,653.36	4,782,663,675,327.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,188,890,272,820.42	3,216,307,060,526.01
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,137,098,381,589.55	3,158,293,171,049.96
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	290,278.00	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	51,791,600,952.87	58,013,889,476.05
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,704,536,618,116.38	1,905,544,531,930.62
	Ажиллагчдад төлсөн	253,288,522,955.43	273,437,654,812.48
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,949,606,783.45	74,550,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	194,233,617,827.04	220,205,179,424.95
	Ашиглалтын зардалд төлсөн	208,305,362,337.53	210,726,003,861.08
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	165,776,782,172.31	190,048,080,025.45
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	782,568,425,914.13	912,070,386,075.42
	Даатгалын төлбөрт төлсөн	1,152,355,002.57	1,210,702,190.00
	Бусад мөнгөн зарлага	33,261,945,123.92	23,296,525,541.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	484,353,654,704.04	1,310,762,528,595.39
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,053,057,183.95	6,649,259,592.58
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	803,906,683.95	690,691,152.58
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
	Хүлээн авсан ногдол ашиг	1,249,150,500.00	5,958,568,440.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	571,520,167,498.77	391,983,280,526.53
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	504,689,938,006.72	334,922,300,595.75
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	65,138,255,818.45	52,279,890,050.78
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,691,973,673.60	4,781,089,880.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(569,467,110,314.82)	(385,334,020,933.95)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,659,540,977.12	116,703,007,286.88
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	115,605,984,622.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Хүү ба урамшууллын орлого	12,659,540,977.12	1,097,022,664.88
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	155,117,944,100.00	1,083,487,812,290.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	155,040,000,000.00	1,083,487,812,290.00
	Төрөл бүрийн хандивт төлсөн	77,944,100.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(142,458,403,122.88)	(966,784,805,003.12)
4	Валютын ханшийн зөрүү	6,182,076,931.23	(31,406,655.83)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(221,389,781,802.43)	(41,387,703,997.51)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	327,425,545,611.96	106,035,763,809.53
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	106,035,763,809.53	64,648,059,812.02

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Хүдэр олборлолт	мян.тн	36,900	36,000	36,000	-	100.0
2	Хүдэр боловсруулалт	мян.тн	32,500	33,200	32,650	(550)	98.3
3	Баяжмалын үйлдвэрлэлт:						
3.1	Зэсийн баяжмал	тн	582,817	584,320	576,644	(7,676)	98.7
3.2	Молибдены баяжмал	тн	6,038	4,980	6,326	1,346	127.0
4	Нийт орлого	сая.төг	2,203,452.4	2,442,541.3	3,130,390.9	687,849.6	128.2
5	Нийт зардал	сая.төг	1,940,351.9	1,880,061.6	1,893,083.1	13,021.5	100.7
6	Цэвэр ашиг	сая.төг	263,100.5	402,441.2	901,547.5	499,106.3	224.0
7	Төсөвт төлсөн нийт дүн	сая.төг	850,466.6	751,835.3	986,438.0	234,602.7	131.2
8	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг	155,040.0	400,000.0	200,000.0	(200,000.0)	50.0
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	6,586	7,005	6,695	(310)	95.6
10	Нийт цалингийн сан	сая.төг	268,382.0	294,407.7	287,708.2	(6,699.5)	97.7
11	Борлуулалтын 1 төгрөгт оногдох зардал	мөнгө	68.5	69.1	56.3	(12.8)	81.5
12	Хөрөнгө оруулалт	сая.төг	665,854.3	892,663.9	436,866.4	(455,797.5)	48.9
13	Нийт авлага	сая.төг	246,319.2	1,289,745.1	156,828.3	(1,132,916.8)	12.2
14	Нийт өглөг	сая.төг	415,664.0	1,368,538.6	990,461.3	(378,077.3)	72.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад орлого хүлээн зөвшөөрөлт, нөхөн сэргээлтийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, үндсэн хөрөнгө, дуусаагүй үйлдвэрлэлийн дансдын бүртгэлд холбогдох залруулгыг хийх, орон сууцны фондын журам боловсруулж батлахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн завсар үеийн аудитын ажлыг 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр, 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл, жилийн эцсийн аудитыг 2022 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Конфиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Энхтөвшин, аудитор Ж.Ариунбаатар, Э.Энхтуул, Г.Шинэцэцэг, Б.Оюунболор, чанарын хяналтыг М.Ундрах, Конфиденсе Аудит ХХК-ийн захирал П.Ариунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн ХБ-111-12/460 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад ашиглагдахуйц дотоод хяналтыг олж тогтоогоогүй ба гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгээгүй.

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Төрийн аудитын байгууллага нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,940,480.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 19,404.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын зорилго нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт үзэл баримтлалыг эрхэмлэж, ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүйгээр оролцогч талуудын, ялангуяа бүс нутгийн оршин суугч иргэдийн эрхийг дээдэлсэн, байгаль орчин, хүн амьтны бие махбодод хор хохиролгүй, мэдлэг, туршлагад тулгуурласан, хууль ёсонд нийцсэн, ил тод үйл ажиллагаа явуулж, хөгжлийн үр шимийг хүн бүхэнд хүргэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зэс, молибдений хүдрийг олборлож, боловсруулах
- Сувилал, нөхөн сэргээх эмчилгээ хийх
- Орхон аймгийн Баян-Өндөр суманд телевизийн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах
- 174-182 МГц радио давтамж ашиглах
- Үндсэн нарийн мэргэжлийн тусламж, амбулатори, оношилгоогоор үйлчлэх
- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшдэг.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар 2019 оны гуравдугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, Эрдэнэт үйлдвэрийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Монгол Улсын хууль

- Нийгмийн даатгалын хуулийн 15 дугаар зүйл “Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ” зүйлийн өөрчлөлт;

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

Нягтлан бодох бүртгэлийн бодлого:

- Тэтгэвэр тэтгэмжийн нөөцийн тооцоолол хийх журмын өөрчлөлт
- Найдваргүй авлагын нөөцийн тооцоолол хийх журмын өөрчлөлт

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	106,035,763.8	64,648,059.8	(41,387,704.0)
Авлага	135,488,667.2	64,649,253.8	(70,839,413.3)
Бараа материал	305,345,018.8	414,956,675.5	109,611,656.6
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	73,066,772.9	92,179,037.6	19,112,264.7
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	1,568,900.0	336,000.0	(1,232,900.0)
Үндсэн хөрөнгө	2,281,858,547.5	2,464,827,989.7	182,969,442.2
Биет бус хөрөнгө	2,482,332,314.8	2,482,700,523.9	368,209.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	7,383,888.1	8,563,097.8	1,179,209.7
Хайгуул ба үнэлгээний зардал	56,734,435.5	71,541,418.5	14,806,983.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	48,507,228.8	72,847,245.7	24,340,016.9
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	778,910.3	708,655.8	(70,254.5)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	34,526,665.2	35,167,000.2	640,334.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,533,627,112.9	5,773,124,958.3	239,497,845.4
Өр төлбөр	415,664,039.8	990,461,282.9	574,797,243.1
Өмч: төрийн	2,658,321.9	2,658,321.9	-
Эздийн өмч	5,115,304,751.2	4,780,005,353.4	(335,299,397.8)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,533,627,112.9	5,773,124,958.3	239,497,845.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 64,648.1 сая төгрөг болж 41,387.7 сая төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 12.9 сая, банк дахь харилцах дансны үлдэгдэл 64,635.2 сая төгрөг бүрдүүлж байгаа ба мөнгөн хөрөнгийн бууралтын 42,358.7 сая төгрөг нь төлбөрийн чадваргүй болсон Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байсан дансны үлдэгдлийг авлагын данс руу шилжүүлсэнтэй холбоотой үүссэн.

Авлага дансны үлдэгдэл 64,649.3 сая төгрөг болж 70,839.4 сая төгрөгөөр буурсанд ААНОАТ, НӨАТ-ын тооцоог урьдчилан төлж тооцоо хаагдсан нь нөлөөлсөн. Авлагын үлдэгдэл нь НӨАТ-ын авлага 287.9 сая төгрөг, борлуулалтын авлага 15,342.4 сая төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах авлага 42,358.7 сая төгрөгөөс бүрдэж байна. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 255.5 сая төгрөгийн авлага ба хугацаа хэтэрсэн 398,545.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр-ийн дагуу авлагын насжилт болон эргэн төлөгдөх магадлалыг харгалзан тооцож байна. Тайлант онд 1,422.6 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, тайлант хугацаанд найдваргүй

авлага болон урьдчилгаа төлбөр төлөгдсөнөөр найдваргүй авлагын нөөц 247.4 сая төгрөгөөр буурсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 414,956.7 сая төгрөг болж 109,611.7 сая төгрөгөөр өссөн нь БНХАУ-ын хил хаагдсанаас шалтгаалж борлуулалт зогсож бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 113,549.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой. Тайлант онд худалдан авалтаар 496,273.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 82.2 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, нийт 496,385.8 сая төгрөгийн бараа нэмэгдсэн.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 3,056.3 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтэрсэнтэй холбоотойгоор хуучирсан тоног төхөөрөмжид ашиглагддаг сэлбэг хэрэгслийг ашиглах боломжгүй болсонтой холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,464,827.9 сая төгрөг болж 182,969.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд шинээр 75,746.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан ба дуусаагүй барилга, их засварын зардал 49,150.6 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах зардал 24,025.6 сая төгрөгөөр, өр барагдуулахаар хүлээн авсан 2,220.3 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр 10,374.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан борлуулсан, 4,254.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, 79,449.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан, 1,229.3 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлж залруулсан байна. Үндсэн хөрөнгөөс төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 600 тоот, 2021 оны 181, 294, 414 тоот тогтоолоор нийт 79,449.7 сая төгрөгийн өртөгтэй, 78,040.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 2,937 хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 137, 162, 202, 284, 333, 403, 497 тоот тогтоолоор 4,254.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 3,437.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй нийт 62 хөрөнгийг төрийн өмчит байгууллагуудад балансаас балансад шилжүүлсэн.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 722,798.1 сая төгрөг болж өмнөх оноос 2,531,264.7 сая төгрөгөөр өсч, 2,252,242.5 сая төгрөгөөр буурч, 279,022.3 сая төгрөгийн цэвэр өсөлттэй байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2021 онд “Өөрөө нунтаглах хэсгийн жилд 6 сая/тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 4-р шугам”-ыг барих төсөлд 158,545.3 сая төгрөг, “Жилд 12 сая/тонн хүдэр боловсруулах хам баяжуулалтын секц барих” төсөлд 24,556.5 сая төгрөг, “Цэвэр ус дамжуулах 3-р шугам угсрах” төсөлд 87,218.6 сая төгрөг, “Баяжуулах үйлдвэрийн өөрөө нунтаглах хэсгийн 2-р шугамын тээрмүүдийг солих ажил”-д 12,034.5 сая төгрөг, “Уурхайчин 2, 3-р хороолол хүртэл дэд бүтэц барих” ажилд 37,722.5 сая төгрөг, “Уурхайчин 3 төслийн дэд бүтцийг барих”-д 21,357.5 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн.

Хойшлогдсон татварын хөрөнгө 72,847.2 сая төгрөг болж 24,340.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн худалдан авалтад ногдох НӨАТ-ын авлагаас шалтгаалсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 990,461.3 сая төгрөг болж 574,797.2 сая төгрөгөөр өссөн нь 2021 оны 11 сард экспортын ачилт зогссонтой холбоотой борлуулалтын орлого цаг хугацаандаа орж ирэхгүй байснаас бэлтгэн нийлүүлэгч компаниудад гэрээний хугацаанд төлбөр тооцоо хийгээгүйгээс өглөг 36,089.2 сая төгрөг, тайлант оны 4 дүгээр улирлын ногдлоос ААНОАТ-ын өглөг 80,949.3 сая төгрөг, АМНАТ-ын өглөг 29,438.9 сая төгрөг, бусад татварын өглөг 9,038.1 сая төгрөг, ХААН банкнаас авсан 22.8 сая ам.доллар буюу 64,952.6 сая төгрөгийн богино хугацаат зээл, баяжмал худалдан авагч компаниас авсан зээлийн үлдэгдэл 17.7 сая ам.долларын буюу 50,653.3 сая төгрөг, Засгийн газрын 211 дүгээр тогтоолын дагуу нэхэмжилсэн төлбөрийн төлөгдөөгүй 153,359.1 сая төгрөг, ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмжийн актуар тооцооллоор 48,695.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан.

Эздийн өмч дансны үлдэгдэл 4,780,005.5 сая төгрөг болж 335,299.4 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 211 тогтоолын дагуу цахилгаан, уур ус, дулаан, энгийн хог хаягдлын төлбөр 1,036,846.9 сая төгрөг болж хуримтлагдсан ашгаа бууруулан бичилт хийсэн, 2020 оны ногдол ашиг 200,000.0 сая төгрөгийг төрийн сангийн дансанд шилжүүлснээс шалтгаалсан.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 677 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд 2021 оны 301 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна. Тайлант онд нийт орлогыг 2,442,541.3 сая төгрөг, нийт зардлыг 1,880,061.6 сая төгрөг, ашгийг 562,479.7 сая төгрөг ба хөрөнгө оруулалтын зардалд 892,663.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 3,130,390.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,893,083.1 сая төгрөгийн зардал гарган, 901,547.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд:						
	Хүдэр олборлолт	мян/тн	36,900	36,000	36,000	0	100.0
	Хүдэр боловсруулалт	мян/тн	32,500	33,200	32,650	(550)	98.3
	Зэсийн баяжмал үйлдвэрлэл	тн	582,817	584,320	576,644	(7,676)	98.7
	Молибдены баяжмал үйлдвэрлэл	тн	6,038	4,980	6,326	1,346	127.0
2	Нийт орлого	сая.төг	2,203,804.4	2,442,541.3	3,130,390.9	687,849.6	128.2
	Үүнээс:						
	Баяжмал борлуулалт	сая.төг	2,173,290.9	2,422,064.6	3,093,882.6	671,818.0	127.7
3	Нийт зардал	сая.төг	1,774,349.9	1,880,061.6	1,893,083.1	(13,021.5)	100.7
	Үүнээс:						
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	966,852.5	1,051,772.7	940,279.4	111,493.3	89.4
	Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	973,499.4	828,288.9	952,803.7	(124,514.8)	115.0
4	Хөрөнгө оруулалт их засвар	сая.төг	665,854.3	892,663.9	436,866.4	455,797.5	48.9
5	Татварын өмнөх ашиг	Сая.төг	429,454.5	562,480.0	1,237,308.0	674,828.0	220.0
6	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	263,100.5	402,441.2	901,547.5	499,106.3	224.0

Тайлант онд хүдэр олборлолтын төлөвлөгөөг 100 хувь, хүдэр боловсруулалтын төлөвлөгөөг 550.0 мянган тонн буюу 1.7 хувиар дутуу биелүүлсэн. Хүдэр боловсруулалтыг 32,650 мянган тоннд хүргэж төлөвлөгөө тасалдалтын хувийг 1.3 болгон бууруулсан буюу 576.6 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн. Хүдэр боловсруулалтын төлөвлөгөө тасарсан боловч боловсруулсан хүдэр дэх молибдены агуулга төлөвлөснөөс 0.003 пункт, молибдены баяжмал дахь метал авалт 5.69 пунктээр нэмэгдсэнээр молибдены баяжмалын үйлдвэрлэлийг 1.3 мянган тонн буюу 27 хувиар давуулан биелүүлж 6.3 мянган тонныг үйлдвэрлэсэн.

Нийт орлогын гүйцэтгэл 3,130,390.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 687,849.6 сая төгрөгөөр илүү байсны 671,817.9 сая төгрөг нь баяжмалын борлуулалтаас үүссэн. Баяжмалын борлуулалтын орлогын өсөлтөд металлын үнэ 920,577.2 сая төгрөгөөр өссөн, ам.долларын ханшийн хэлбэлзэл 50.2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн бол баяжмалын үйлдвэрлэлийн тоо хэмжээний төлөвлөгөөнд хүрч чадаагүйгээс 248,387.5 сая төгрөгөөр орлого буурсан нь нөлөөлсөн.

Харин бусад бүтээгдэхүүн (цахилгаан, дулаан, цэвэр ус, бохир ус, ацетилен, хүчил төрөгч, металл хийц)-ийн борлуулалтын орлого нь үнийн өсөлтөөс 229.1 сая төгрөгөөр нэмэгдэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээний бууралтаас 651.1 сая төгрөгөөр хасагдсан байна. 2021 оны бусад орлогын төлөвлөгөө нийт 16,031.6 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд үүнд валютын ханшийн олз 5,890.2 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлого 12,576.9 сая төгрөг, өмчийн аргаар бүртгэсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын олз 2,830.9 сая төгрөг, бусад борлуулалт 918.2 сая төгрөг, нийтийн хоолны хэсгийн орлого 162.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн бол коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10.4 дэх заалтын дагуу банкны харилцах дансанд хүү тооцогдоогүй тул санхүүгийн орлогын төлөвлөгөө 2,130.0 сая төгрөгөөр, мөн нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор нийгмийн цехүүдийн үйл ажиллагааг хязгаарласнаар орлогын төлөвлөгөө нь 3,993.8 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн.

Нийт зардлын гүйцэтгэл 1,893,083.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 13,021.5 сая төгрөг буюу 0.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2021 онд дэлхийн зах зээл дээрх цэвэр 1 тонн зэсийн үнэ төлөвлөснөөс 2,814.74 ам.доллараар өсч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөвлөснөөс 170,107.0 сая төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь үйлдвэрийн газрын нийт зардлыг төлөвлөснөөс 13,021.5 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн. Харин ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өсөлтийг эс тооцвол нийт зардлыг 157,085.5 сая төгрөгөөр бууруулан ажилласан.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 854 нэр төрлийн их засвар, барилга засвар, эрдэм шинжилгээ туршилт судалгаа, ХАБЭА-ын нөхцөлийг сайжруулах иж бүрэн арга хэмжээ, бараа худалдан авалт, геологи хайгуул, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, төсөл, зөвлөх үйлчилгээ зэрэг ажлуудыг өөрийн эх үүсвэрээс 892,663.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 249 нэр төрлийн 436,866.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж 48.9 хувийн биелэлттэй байна. БНХАУ тээврийн хөдөлгөөний хязгаарлалт хийж, хилийн хорио тавьсан, цар тахлын улмаас гэрээний гүйцэтгэлүүд хойшилсон зэргээс шалтгаалан 2021 онд төлөвлөсөн ажлуудын биелэлтэд сөргөөр нөлөөлсөн.

Тайлант онд цэвэр ашиг 901,547.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 499,106.3 сая төгрөгөөр буюу 2.2 дахин илүү байгаад орлогын төлөвлөгөөг 687,849.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн.

ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн А-1/1100 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 200,000.0 сая төгрөгийн ногдол ашиг төрийн сангийн ногдол ашгийн дансанд төвлөрүүлсэн байна. Мөн түрээсийн төлбөрийн 40 хувь болох 64.5 сая төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлжээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 677 дугаар тогтоолыг үндэслэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2020 оны 12 сарын 21-ний өдрийн А/718 дугаар тушаалаар баталсан. Батлагдсан төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2020 оны 12 дугаар сарын 30-нд байршуулсан. Батлагдсан төлөвлөгөөг 7 удаа өөрчилж сангийн ямаар хянуулж баталгаажуулан тодотгол хийсэн байна. Сүүлчийн тодотголоор 973,599.5 сая төгрөгийн санхүүжилттэй 1190 худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар зөвшөөрөгдсөн.

Үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотголыг сангийн яам, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар хянуулж, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд бүрэн байршуулж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим

хэлбэрээр зохион байгуулсан байна. Энэ онд нийт 734,513.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 693,702.1 сая төгрөгийн үнийн дүнтэй 1003 гэрээ байгуулжээ. Компанийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны бодлогын газар нь үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны “нэг цонх”-ны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор судалгаа шинжилгээ хийж, анхан шатны мэдээлэл боловсруулах “Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны цахим систем”-ийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаад байгаа нь дэвшилтэт технологи, сайн туршлага болсон.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 зааснаар тайлант онд нийт 6,347,420.3 сая төгрөгийн 4,562 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас, 819.2 сая төгрөгийн 68 мэдээллийг ил тод байршуулаагүй.

Шилэн дансанд байршуулсан зорилтот түвшний болон хөрөнгө оруулалтын тайлангуудын үзүүлэлтүүдийг хуулийн дагуу бүрэн гүйцэд тайлагнадаггүй, тайлбарыг хангалтгүй хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар шатахууны зардал, нүүрсний зардал, дугуйн зардал, авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон нийгмийн цехүүдийн бүртгэл гэсэн 5 чиглэлд дотоод хяналтын үр нөлөөг үнэлж үзсэн ба холбогдох зөвлөмжүүдийг өгсөн. Үүнээс нийгмийн цехтэй холбоотой зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 56,696.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 68,481.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснөөс албан шаардлага 90 хувь, зөвлөмж 91.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	10	56,696.1	9	11,429.0	1	42,358.7	90.0
Зөвлөмж	11	68,481.6	10	36,654.0	1	31,827.6	91.0
Нийт дүн	21	125,177.7	19	48,083.0	2	74,186.3	90.5

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

1. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэсэн. Аудитын явцад үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний тайлан, санхүүгийн тайланд тусгасан байдлыг давтан шалгахад зарим хөрөнгийн үнэлгээ бодит нөхцөл, зах зээлийн үнэлгээ зэрэгтэй нийцэхгүй, харьцангуй зөрүүтэй үнэлэгдсэн байсныг үнэлгээчид дахин нягталж 31,827.6 сая төгрөгийн хөрөнгийг залруулах нөхцөл үүссэн нь санхүүгийн тайланд үзүүлэх материаллаг нөлөө ихтэй байгаа тул нэмэлт санхүүжилт, зардал гаргахгүйгээр хөрөнгийг дахин үнэлгээний стандарт, заавар, журмын дагуу үнэн, зөв, бодитой хийлгэж санхүүгийн тайланд залруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

2. Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгаа 45,267.1 сая төгрөгийг татан төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагын дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг татан авах талаар хамтран ажиллаж тайлант онд 2,908.4 сая төгрөгийн гүйлгээ хийлгэсэн. Харилцах данс дахь үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй, тохиролцоонд хүрч чадаагүй тул 2021 оны 12 сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 42,358.7 сая төгрөгийг авлагын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан доорх асуудлуудыг дараагийн аудитаар шалгахар шийдвэрлэлээ. Үүнд:

- Медипас ХХК-ийн хөрөнгийг хураан авч Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр бүртгэх төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг хэрэгжүүлсэн байдал;
- Эдийн засгийн албаны гаргаж байгаа төсөв төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн шинжилгээ, дүгнэлтүүд нь ул үндэслэлтэй эсэх;
- Дахин үнэлгээний асуудлыг шийдсэн, түүний бүртгэлийн залруулгыг хийсэн эсэх;
- Орон сууцны сан бүрдүүлэх, цаашид түрээслэх зорилгоор авсан орон сууцны бүртгэлийн зохистой эсэх;
- Хөлсөөр ажиллах гэрээтэй ажиллагсдын гэрээ, ажлын гүйцэтгэл, цалин хөлс зэрэг нь хууль, журамд нийцэж байгаа эсэхийг шалгах.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 230,946.6 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 214,704.2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 16,242.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 230,946.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 19,404.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшингээс 211,541.8 сая төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

1. Үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгүүдийг үнэлсэн баг 2020 онд хийсэн дахин үнэлгээний тайлангаа 2021 онд хэд хэдэн удаа засварлаж албан ёсоор 1 удаа, албан бусаар 3-4 удаа өөрчилж ирүүлсэн нь тайлангуудын дүн хоорондоо 124,890.6 сая төгрөгийн зөрүүтэй, техникийн алдаатай байна.

Хөрөнгийн үнэлгээ хийх үедээ ойрын жилүүдэд данснаас хасагдах байсан дахин үнэлгээ хийх шаардлагагүй, эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгүүдийг хэт өндөр дүнгээр үнэлсэн. Эдгээр хөрөнгүүдийг 2021 оны жилийн эцсээр данснаас хасахтай холбогдуулан 27,517.4 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэнээр байгууллагын ашгийг хийсвэрээр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 “үнэн зөв байх” заалт, СТОУС Онолын үзэл баримтлал Бүлэг-3, НББОУС 16.31 Үндсэн хөрөнгө, дахин үнэлгээ заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

2. Сэлэнгэ аялал жуулчлалын цогцолборын зочид буудлын үйл ажиллагаанд тавих хяналт сул байснаас зарим зочдоос тарифын дагуу өрөөний болон бусад үйлчилгээний 39.9 сая төгрөгийн төлбөрийг авалгүй байгууллагыг хохироосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 11.2 "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", СТОУС Онолын үзэл баримтлал 4.47 Орлогын хүлээн зөвшөөрөлт заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

3. Нийгмийн цехүүд буюу үндсэн үйл ажиллагаа, үйлдвэрлэлээс бусад үйл ажиллагаа эрхэлдэг 11 нэгжээс сэлэнгэ аялал жуулчлалын бааз, түүний харьяа зочид буудал, оёдлын цех, ресторан, соёлын ордон, дээд сургууль зэрэг өөрийгөө санхүүжүүлэх боломжтой нийгмийн цехүүд алдагдалтай ажиллаж байна. Нийгмийн цехүүдийн 2021 оны санхүүгийн тайлан дахь алдагдлын хэмжээ 19,553.2 сая төгрөг болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 67 дугаар зүйл дотоод хяналт шалгалт 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

4. Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнуудад шүүхийн шийдвэрийн дагуу 108.0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохдоо байгууллагаас төлж, буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл захиргааны байгууллага хохирлоо барагдуулах 103.1. "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

5. Нийт 66 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, үйлчилгээ авч, төлбөр төлснөөс 162.0 сая төгрөгийн төлбөр авсан 13 байгууллага нь өөрийн албан ёсны сайтгүй, ямар үйлчилгээ үзүүлсэн нь тодорхой бус, ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл нягтлан бодох бүртгэл хөтлөх 14.3.1 “Анхан шатны баримт бүрдүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

6. Хүдрийн овоолгын өртгийг тооцож, санхүүгийн тайланд тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийн дагуу хэд хэдэн ажлууд хийгдэж байгаа хэдий ч үр дүн эцэслэн гараагүйн улмаас 2021 оны жилийн эцсээрх санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь НББОУС2 *Бараа материал*-ын 14-т “дайвар бүтээгдэхүүнд өртөг шингээхгүй боловч цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэх” заалттай нийцэхгүй, өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

7. Үндэсний Хөрөнгө оруулалтын банканд байгаа мөнгөн хөрөнгийг татан авч чадаагүй 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 42,358.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

8. Дотоод хяналтын хэлтсийн шалгалтын ажлын илрүүлэлт, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна. Уг хэлтсийн ажиллах журмыг батлаагүй байгаа нь байгууллагын дотоод хяналтын тогтолцоонд эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 67 дугаар зүйл дотоод хяналт шалгалт 67.1”Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

9. Нийт борлуулалтад эзлэх дотоодын борлуулалт 0.5 хувь боловч НӨАТ-ын буцаан авалтын тооцооллыг энэ хувьтай уялдуулаагүй, мөн үйл ажиллагааны бус зардалд холбоотой НӨАТ-ыг буцааж авахаар бүртгэсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн албан татвар хасалт хийх 14.9 "Албан татвар суутган төлөгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг албан татвар ногдох, үлдсэн хэсгийг албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход, эсхүл албан татвар ногдох орлого олоход хамааралгүй үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулсан тохиолдолд зөвхөн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд ногдох албан татварыг хасч тооцно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

10. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан хамтын гэрээний 8 дугаар бүлэгт заасныг зөрчиж, үйлдвэрийн ажилтан болон тэдгээрт хамааралгүй хүмүүст нийт 74.2 сая төгрөгийн сургалтын төлбөр олгосон байна.

Энэ нь ТӨҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан хамтын гэрээний 8.1-т заахдаа үйлдвэрийн газарт тав ба түүнээс дээш жил тасралтгүй ажиллаж байгаа ажилтны 1 хүүхдүүдийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн нөөцтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Уурхай хаагдах үеийн нөхөн сэргээлтийн нөөцийг анхлан тооцоолохдоо үйлдвэр 2056 он хүртэл ажиллах төсөөлөлд үндэслэсэн. 2021 онд нөөцийг шинэчлэн баталж цаашид 60 жил ажиллахаар буюу 2080 он хүртэл ажиллаж уурхайн талбайг эрс тэлэх, шинэ бүтээн байгуулалтууд, хаягдлын далангийн өргөтгөл хийгдэх шинэ нөхцөл байдал үүссэн. Үүнээс шалтгаалан одоо хэрэглэж буй нөхөн сэргээлтийн нөөцийн бодлого тохиромжгүй болсон. Энэ нь НББОУСЗ7, *Болзошгүй хөрөнгө, өр төлбөр ба нөөц*, НББОУС-ын тайлбар 1. Одоогийн нөхөн сэргээлтийн нөөцийн өөрчлөлт-тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нөхөн сэргээлтийн нөөцийн бодлого ба тооцооллыг өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тохирч буй эсэхэд үнэлэлт өгч шинэчлэх, уурхай хаагдах үеийн нөхөн сэргээлтэд зориулан мөнгөн хэлбэрээр сан үүсгэж байршуулах.

2. Түрээсийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажиллагсдад түрээслүүлдэг амьдрах зориулалттай орон сууцнуудын 1 метр квадрат талбайн үнэлгээ хэт бага буюу 683 төгрөг байна. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн жишиг үнэ 4,500 төгрөгөөр тооцоолж үзэхэд жилд ойролцоогоор 619.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж алдсан.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Түрээсийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн жишиг үнэтэй дүйцүүлэн байгууллагыг үр ашигтай байлгахад шинэчлэн тогтоох.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажилтнуудад болон ахмадуудад түрээслүүлдэг орон сууцны цахилгаан, цэвэр бохир халуун ус, сууц өмчлөгчдийн холбооны төлбөр, дулаан зэрэг ашиглалтын зардлуудыг түрээслэгч ажилтнуудын цалингаас тогтмол дүнгээр суутган авч холбогдох байгууллагуудтай тэдний өмнөөс тооцоо хийдэг байна. Нягтлан бодох бүртгэлд үйл ажиллагаатай холбоогүй, шаардлагагүй гүйлгээнүүдийн тоо ихэсч, бүртгэлд тавих хяналтыг сулруулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1. "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам

тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Түрээслэгчдийн ашиглалтын төлбөрийг тэдний өмнөөс дамжуулж төлөхгүйгээр Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-тай шууд гэрээ байгуулан төлүүлдэг болгох.

4. Нийгмийн цехүүдтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон сууцны дэд бүтэц барих, орон сууцны фонд бүрдүүлэх, махны зоорийн барилга барих, соёл спортын цогцолбор байгуулах, Сэлэнгэ амралтын бааз дахь амралтын байр шинээр барих зэрэгт их хэмжээний санхүүжилт хийсэн байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар баталж байгаа ба өмнөх жилийн цэвэр ашгийн талаас илүү хувийг нийгмийн чиглэлийн нэмүү өртөг бий болгохгүй төслүүдэд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн урсгалыг үйлдвэрлэлийн гол үйл ажиллагааг дэмжих нэмүү өртөг бий болгох төслүүдийн санхүүжилтэд тэргүүн ээлжинд зарцуулах замаар мөнгөн хөрөнгийн менежментийг оновчтой зөв хийх

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Уурхайчин 1 хорооллыг улсын комисс хүлээж авсан боловч дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа бөгөөд тус байрны өртөгт шингэвэл зохих дэд бүтцийг барьж байгуулсан зардлуудыг байрны өртөгт шингээж бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС16, Үндсэн хөрөнгө -тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Уурхайчин 1 хорооллоос авсан орон сууцны барилгуудад дуусаагүй үйлдвэр дансанд бүртгэгдсэн дэд бүтцийг барьж байгуулахад гарсан зардлыг хуваарилан бүртгэх.

6. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Люксвүүд групп ХХК-аас худалдан авч байгаа 19 ширхэг амины орон сууц нь дундаж хэрэглээнээс хэтэрхий том 180-280 метр квадрат хүртэлх талбайтай ба 80 хувийн гүйцэтгэлтэй тооцоо нийлж гэрээний дагуу төлбөрийг төлсөн байна. Эдгээр хөрөнгийг 100 хувь гэрээний үнээр хөрөнгөд бүртгэж, төлөгдөөгүй 20 хувиар өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 67 дугаар зүйлийн 67.1 “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө дансанд 100 хувь гүйцэтгэлийн дүнгээр бүртгэсэн байруудыг гүйцэтгэлийн хувьд үндэслэж дуусаагүй барилга дансанд буцаан залруулж бүртгэх.

7. Борлуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу борлуулах эцсийн үнийг сонгох хугацаа нь борлуулалт хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойно тохиолддог. Энэ нөхцөл байдлаас үүссэн үнийн зөрүүг дахин тооцоолдог ба уг дүнгээр борлуулалтын орлогод залруулга хийхдээ валютын ханшийг буруу сонгосон.

Энэ нь СТОУС 15, Гэрээний орлого, НББОУС 21, Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөөтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Борлуулалтын залруулгын тооцооллыг хийхдээ борлуулалт хүлээн зөвшөөрсөн өдрийн валютын албан ханшийг хэрэглэх.

8. Балансын данстай холбоотой

Илрүүлэлт:

Баяжмал худалдан авагч компаниудын нэг болох Таурус металс компаниас авсан богино хугацаат зээлийн гэрээнд "Зохион байгуулалтын шимтгэл"-ийг 1.95 хувиар тооцож, зээл орж ирсэн эхний өдөр өгөхөөр заасан боловч нягтлан бодох бүртгэлд шимтгэлийн өглөг үүсгэж бүртгээгүй байна.

Энэ нь Санхүүгийн тайлагналын суурь зарчим 1.17, Аккруэл сууриар бүртгэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зээлийн гэрээний дагуу зохион байгуулалтын шимтгэлийн өглөгийг тайлант үед аккруэл сууриар өглөг, зардал хүлээн зөвшөөрч бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгүүдийг үнэлсэн баг 2020 онд хийсэн дахин үнэлгээний тайлангаа 2021 онд хэд хэдэн удаа засварлаж албан ёсоор 1 удаа, албан бусаар 3-4 удаа өөрчилж ирүүлсэн нь тайлангуудын дүн хоорондоо 124,890.6 сая төгрөгийн зөрүүтэй, техникийн алдаатай байна. Хөрөнгийн үнэлгээ хийх үедээ ойрын жилүүдэд данснаас хасагдах байсан дахин үнэлгээ хийх шаардлагагүй, эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгүүдийг хэт өндөр дүнгээр үнэлсэн. Эдгээр хөрөнгүүдийг 2021 оны жилийн эцсээр данснаас хасахтай холбогдуулан 27,517.4 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэнээр байгууллагын ашгийг хийсвэрээр нэмэгдүүлсэн байна.	Дахин үнэлгээний тайланг үнэн зөв болгож эцэслэх, дахин үнэлгээний бичилтийг үнэн зөв болгож залруулга хийх, албан шаардлага хүргүүлэх	1	152,408,083.9							1	152,408,083.9		
2	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Сэлэнгэ аялал жуулчлалын цогцолборын зочид буудлын үйл ажиллагаанд тавих хяналт сул байснаас зарим зочдоос тарифын дагуу өрөөний болон бусад үйлчилгээний 39.9 сая төгрөгийн төлбөрийг авалгүй байгууллагыг хохироосон байна.	Сэлэнгэ аялал жуулчлалын цогцолборын зочид буудлын үйл ажиллагаа, орлогод тавих хяналтыг сайжруулж ажиллах	1	39,960.0							1	39,960.0		

3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Нийгмийн цехүүд буюу үндсэн үйл ажиллагаа, үйлдвэрлэлээс бусад үйл ажиллагаа эрхэлдэг 11 нэгжээс Сэлэнгэ аялал жуулчлалын бааз, түүний харьяа зочид буудал, оёдлын цех, ресторан, соёлын ордон, дээд сургууль зэрэг өөрийгөө санхүүжүүлэх боломжтой нийгмийн цехүүд алдагдалтай ажиллаж байна. Нийгмийн цехүүдийн 2021 оны санхүүгийн тайлан дахь алдагдлын хэмжээ 19,553.2 сая төгрөг болсон байна	Нийгмийн цехүүдийн менежментийг сайжруулах, дотоод хяналтыг үр дүнтэй болгох замаар алдагдалгүй ажиллуулах талаар албан шаардлага хүргүүлэх	1	19,553,224.0						1	19,553,224.0				
4	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнуудад шүүхийн шийдвэрийн дагуу 108.0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгоходоо байгууллага төлж, буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	Нөхөн төлбөрийг Буруутай этгээдүүдээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх	1	108,005.4						1	108,005.4				
5	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Нийт 66 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, үйлчилгээ авч, төлбөр төлснөөс 162.0 сая төгрөгийн төлбөр авсан 13 байгууллага нь өөрийн албан ёсны сайтгүй, ямар үйлчилгээ үзүүлсэн нь тодорхой бус, ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүй байна.	Ажил, үйлчилгээ үзүүлээгүй байгууллагуудаас төлбөрийг буцаан авч байгууллагыг хохиролгүй болгох, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хавтгайрсан гэрээ хэлцэл хийхгүй байх	1	162,000.0						1	162,000.0				
6	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Хүдрийн овоолгын өртгийг тооцож, санхүүгийн тайланд тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийн дагуу хэд хэдэн ажлууд хийгдэж байгаа хэдий ч үр дүн эцэслэн гараагүйн улмаас 2021 оны жилийн эцсээрх санхүүгийн тайланд тусгаагүй байна	Овоолгын өртгийг бүртгэх ажиллагааг түргэсгэж, санхүүгийн тайландаа тусгах албан шаардлага хүргүүлэх	1	-						1	-				
7	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Үндэсний Хөрөнгө оруулалтын банканд байгаа мөнгөн хөрөнгийг татан авч чадаагүй 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 42,358.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	Мөнгөн хөрөнгийг буцаан татаж авах арга хэмжээг эрчимжүүлж бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх	1	42,358,713.7						1	42,358,713.7				

8	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Дотоод хяналтын хэлтсийн шалгалтын ажлын илрүүлэлт, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна. Уг хэлтсийн ажиллах журмыг батлаагүй байгаа нь байгууллагын дотоод хяналтын тогтолцоонд эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.	Дотоод хяналтын хэлтсийг үр дүнтэй ажиллуулах, хийсэн ажлыг байгууллагад ашиглах, чиглэл заавраар хангах, үйл ажиллагааг жигдрүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-							
9	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Нийт борлуулалтад эзлэх дотоодын борлуулалт 0.5 хувь боловч НӨАТ-ын буцаан авалтын тооцооллыг энэ хувьтай уялдуулаагүй, мөн үйл ажиллагааны бус зардалд холбоотой НӨАТ-ыг буцааж авахаар бүртгэсэн байна.	Татварын тооцооллыг нэг аргачлалаар үнэн зөв хийх зөвлөмж хүргүүлэх	1	-					1	-							
10	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Уурхай хаагдах үеийн нөхөн сэргээлтийн нөөцийг анхлан тооцоолохдоо үйлдвэр 2056 он хүртэл ажиллах төсөөлөлд үндэслэсэн. 2021 онд нөөцийг шинэчлэн баталж цаашид 60 жил ажиллахаар буюу 2080 он хүртэл ажиллаж уурхайн талбайг эрс тэлэх, шинэ бүтээн байгуулалтууд, хаягдлын далангийн өргөтгөл хийгдэх шинэ нөхцөл байдал үүссэн. Үүнээс шалтгаалан одоо хэрэглэж буй нөхөн сэргээлтийн нөөцийн бодлого тохиромжгүй болсон.	Нөхөн сэргээлтийн нөөцийн бодлого ба тооцооллыг өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тохирч буй эсэхэд үнэлэлт өгч шинэчлэх, уурхай хаагдах үеийн нөхөн сэргээлтэд зориулан мөнгөн хэлбэрээр сан үүсгэж байршуулах.	1	-										1			
11	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Ажиллагсад түрээслүүлдэг амьдрах зориулалттай орон сууцнуудын 1 метр квадратын үнэлгээ хэт бага буюу 683 төгрөг байна. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн жишиг үнэ 4,500 төгрөгөөр тооцоолж үзэхэд жилд ойролцоогоор 619.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж алдсан .	Түрээсийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн жишиг үнэтэй дүйцүүлэн байгууллагыг үр ашигтай байлгахар шинэчлэн тогтоох.	1	619,590.7										1		619,590.7	

12	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Ажилтнуудад болон ахмадуудад түрээслүүлдэг орон сууцны цахилгаан, цэвэр бохир халуун ус, сууц өмчлөгчдийн холбооны төлбөр, дулаан хог зэрэг зардлуудыг түрээслэгч ажилтнуудын цалингаас тогтмол дүнгээр суутган авч холбогдох байгууллагуудтай тэдний өмнөөс тооцоо хийдэг байна. Энэ бүртгэлийг түрээслэгчийн нэрээр тооцооны данс үүсгэж бүртгэдэггүй, хяналт хангалтгүй байна. Нийгмийн цехүүдийн нэг эмнэлэг сувиллын авлага борлуулалтыг цаг тухай бүрт бүртгэдэггүй. Мөнгөн хөрөнгийн бүртгэлийг хураангуйлдаг, авлагыг харилцагчдын нэрээр хөтөлдөггүй байна.	Түрээслэгчдийн ашиглалтын төлбөрийг тэдний өмнөөс дамжуулж төлөхгүйгээр “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-тай шууд гэрээ байгуулан төлүүлэх	1	335,454.2								1	335,454.2
13	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Орон сууцны дэд бүтэц барих, орон сууцны фонд бүрдүүлэх, махны зоорийн барилга барих, соёл спортын цогцолбор байгуулах, Сэлэнгэ амралтын бааз дахь амралтын байр шинээр барих зэрэгт их хэмжээний санхүүжилт хийсэн байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар баталж байгаа ба өмнөх жилийн цэвэр ашгийн талаас илүү хувийг нийгмийн чиглэлийн нэмүү өртөг бий болгохгүй төслүүдэд зарцуулсан.	Үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн урсгалыг үйлдвэрлэлийн гол үйл ажиллагааг дэмжих нэмүү өртөг бий болгох төслүүдийн санхүүжилтэд тэргүүн ээлжинд зарцуулах замаар мөнгөн хөрөнгийн менежментийг оновчтой зөв хийх зөвлөмж өгөх	1	-								1	-
14	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Уурхайчин 1 хорооллыг улсын комисс хүлээж авсан боловч дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа бөгөөд тус байрны өртөгт шингэвэл зохих дэд бүтцийг барьж байгуулсан зардлуудыг байрны өртөгт шингээж бүртгээгүй байна.	Дуусаагүй барилга дансанд байгаа дүнг бүртгэлийн бодлогын дагуу тохирох дансдад хуваарилах зөвлөмж өгөх	1	6,093,000.0								1	6,093,000.0
15	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Люксвүүд групп ХХК-аас худалдан авч байгаа 19 ширхэг амины орон сууц нь дундаж хэрэглээнээс хэтэрхий том 180-280 метр квадрат хүртэлх талбайтай ба 80.0 хувийн	Үндсэн хөрөнгө дансанд 100.0 хувь гүйцэтгэлийн дүнгээр бүртгэсэн байруудыг гүйцэтгэлийн хувьд	1	1,417,100.0								1	1,417,100.0

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			гүйцэтгэлтэй тооцоо нийлж гэрээний дагуу төлбөрийг төлсөн байна. Эдгээр хөрөнгийг 100.0 хувь гэрээний үнээр хөрөнгөд бүртгэж, төлөгдөөгүй 20.0 хувиар өглөг үүсгэсэн байна.	үндэслэж дуусаагүй барилга дансанд буцаан залруулж бүртгэх зөвлөмж өгөх												
16	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Баяжмал худалдан авагч компаниудын нэг болох Таурис метале компаниас авсан богино хугацаат зээлийн гэрээнд "Зохион байгуулалтын шимтгэл"-ийг 1.95 хувиар тооцож, зээл орж ирсэн эхний өдөр өгөхөөр заасан боловч нягтлан бодох бүртгэлд шимтгэлийн өглөг үүсгэж бүртгээгүй.	Зээлийн гэрээний дагуу зохион байгуулалтын шимтгэлийн өглөгийг тайлант үед аккруэл сууриар өглөг, зардал хүлээн зөвшөөрч бүртгэх.	1	7,777,224.0							1	7,777,224.0		
17	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу борлуулах эцсийн үнийг сонгох хугацаа нь борлуулалт хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойно тохиолддог. Энэ нөхцөл байдлаас үүссэн үнийн зөрүүг дахин тооцоолдог ба уг дүнгээр борлуулалтын орлогод залруулга хийхдээ валютын ханшийг буруу сонгосон.	Борлуулалтын залруулгын тооцооллыг хийхдээ борлуулалт хүлээн зөвшөөрсөн өдрийн валютын албан ханшийг хэрэглэх.	1	-							1	-		
18	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан хамтын гэрээний 8 дугаар бүлэгт заасныг зөрчиж, үйлдвэрийн ажилтан болон тэдгээрт хамааралгүй хүмүүст нийт 74.2 сая төгрөгийн сургалтын төлбөр олгосон байна.	Сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгохдоо гэрээний заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх	1	74,251.1				1	74,251.1					
ДҮН					18	230,946,607.0	-	-	-	-	10	214,704,238.1	-	-	8	16,242,368.9
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	АХГ-2022/58/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд нийт 6,347.4 сая төгрөгийн 4,562 мэдээллийг ил тод байршуулахаас 819.2 сая төгрөгийн 68 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх, хариуцсан ажилтан хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх	1	819,229.5					1	819,229.5				
ДҮН					1	819,229.5	-	-	-	-	1	819,229.5	-	-	-	-
НИЙТ ДҮН					19	231,765,836.5	-	-	-	-	11	215,523,467.6	-	-	8	16,242,368.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 607/АО150053
АХГ-2022/58/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүдрийн овоолгын өртгийг тооцож, санхүүгийн тайланд тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийн дагуу ажлууд хийж байгаа ч үр дүн эцэслэн гараагүйн улмаас 2021 оны жилийн эцсээрх санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 2 “Бараа материал”-ын 14 “дайвар бүтээгдэхүүнд өртөг шингээхгүй боловч цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэх” заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хүдрийн овоолгын өртгийг бүртгэх ажиллагааг эрчимжүүлэх, санхүүгийн тайланд тусгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-331.Docx

0001081703



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 608/А.0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/58/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт 66 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тооцоо дуусгаснаас 162,000,000 төгрөгийн төлбөрийг төлж, тооцоо нийлсэн 13 байгууллага нь өөрийн албан ёсны сайтгүй, ямар үйлчилгээ үзүүлсэн нь тодорхой бус, ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил, үйлчилгээ үзүүлээгүй байгууллагуудаас төлбөрийг буцаан авч байгууллагыг хохиролгүй болгох, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хэлцлийг хавтгайруулан хийхгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

MO.10.10.20.Bu.hig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-330.Docx

0001081701



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 609/А0150053
АХГ-2022/58/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнуудад шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлбөрийг байгууллагаас олгож, буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрийн дагуу олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдүүдээр төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНС АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9019120396

\\10.10.10.2001c-hq_khreev\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-329.Docx

0001081699



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 614/А/0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/58/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт борлуулалтад эзлэх дотоодын борлуулалт 0.5 хувь боловч нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авалтын тооцооллыг энэ хувьтай уялдуулаагүй, үйл ажиллагааны бус зардалтай холбоотой нэмэгдсэн өртгийн албан татварыг буцааж авахаар бүртгэсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.9 "Албан татвар суутган төлөгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг албан татвар ногдох, үлдсэн хэсгийг албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход, эсхүл албан татвар ногдох орлого олоход хамааралгүй үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулсан тохиолдолд зөвхөн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд ногдох албан татварыг хасч тооцно" заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авалтыг зөв бүртгэх зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНС АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.2018\mcag_khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-328.Docx

0001081697



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 616/А.0150033

Улаанбаатар хот

АХГ-2022/58/НА-СТА-ТОН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод хяналтын хэлтсийн хяналт шалгалтын ажлын илрүүлэлт, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна. Уг хэлтсийн ажиллах журмыг батлаагүй байгаа нь байгууллагын дотоод хяналтын тогтолцоонд эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 67 дугаар зүйлийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Дотоод хяналтын хэлтсийг үр дүнтэй ажиллуулах, чиглэл заавраар хангах, үйл ажиллагааг жигдрүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

WD.10.10.20\Bichig_Kherem\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-333.Docx

0001081707



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 617/А0150053

Улаанбаатар хот

АХГ - 2022/58/НБ - СТА - ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгүүдийг үнэлсэн баг 2020 онд хийсэн дахин үнэлгээний тайлангаа 2021 онд хэд хэдэн удаа засварлаж, албан ёсоор 1 удаа, албан бусаар 3-4 удаа өөрчилж ирүүлсэн. Тайлангуудын дүн хоорондоо 124,890,661,780 төгрөгийн зөрүүтэй, техникийн алдаатай байна.

Хөрөнгийн үнэлгээ хийх үедээ ойрын жилүүдэд данснаас хасагдах дахин үнэлгээ хийх шаардлагагүй, эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгүүдийг хэт өндөр дүнгээр үнэлсэн. Эдгээр хөрөнгүүдийг 2021 оны жилийн эцсээр данснаас хасахтай холбогдуулан 27,517,422,084 төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэнээр байгууллагын ашгийг хийсвэрээр нэмэгдүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх," Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал Бүлэг-3 Ач холбогдолтой санхүүгийн мэдээллийн чанарын шинжүүд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 16 Үндсэн хөрөнгө, Параграф 31 Дахин үнэлгээний загвартай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дахин үнэлгээний тайланг үнэн зөв болгож эцэслэх, дахин үнэлгээний бичилтийг үнэн зөв болгож залруулга хийх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006189
\\10.10.10.20\Fichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-325.Docx

0001081691



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 618/10150053
АХГ-2022/58/ХТ - СТБ-ТӨҮГ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд нийт 819,229,537.00 төгрөгийн 68 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5. "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын хариуцлага ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

П.АРИУНАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тогтруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-324.Docx
9010120396

0001081689



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 619/А.0150053
АХГ-2022/58/НВ-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн цехүүдийн буюу үндсэн үйл ажиллагаа, үйлдвэрлэлээс бусад үйл ажиллагаа эрхэлдэг Сэлэнгэ аялал жуулчлалын бааз, түүний харьяа зочид буудал, оёдлын цех, ресторан, соёлын ордон, дээд сургууль зэрэг өөрийгөө санхүүжүүлэх боломжтой нийгмийн цехүүд алдагдалтай ажиллаж байна. Нийгмийн цехүүдийн 2021 оны санхүүгийн тайлан дахь алдагдлын хэмжээ 19,553,223,987 төгрөг болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 67 дугаар зүйл Дотоодын хяналт шалгалт, 1.Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн цехүүдийн менежментийг сайжруулах, дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах алдагдалгүй ажиллуулах арга хэмжээ авах, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий няглан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНС АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-327.Docx

0001081695



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 620/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/58/НЛ-СГА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан хамтын гэрээний 8 дугаар бүлэгт заасныг зөрчиж, үйлдвэрийн ажилтан болон тэдгээрийн гэр бүлд хамааралгүй хүмүүст нийт 74,251,100 төгрөгийн сургалтын төлбөр олгосон байна.

Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан хамтын гэрээний 8.1 "үйлдвэрийн газарт тав ба түүнээс дээш жил тасралтгүй ажиллаж байгаа ажилтны 1 хүүхдийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгоходоо гэрээний заалтыг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
П.АРИУНАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
90191 10.10.20\Bichig_Kherem\Alban_Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-334.Docx

0001081741



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 621/А0150053

Улаанбаатар хот

АХТ-2022/58/ХА-СА-ТЦА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэлэнгэ аялал жуулчлалын цогцолборын зочид буудлын үйл ажиллагаанд тавих хяналт сул байснаас зарим зочдоос тарифын дагуу өрөөний болон бусад үйлчилгээний 39,960,000 төгрөгийн төлбөрийг авалгүй байгууллагыг хохироосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", СТОУС Онолын үзэл баримтлал 4.47 Орлогын хүлээн зөвшөөрөлт заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сэлэнгэ аялал жуулчлалын цогцолборын зочид буудлын үйл ажиллагаа, орлогод тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэн, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

КОНФИДЕНС АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

П.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006100
10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-326.Docx
9019120396

0001081693